

БАТЛАВ  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН ВИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ХОВД АЙМГИЙН "ХОВД" НИСЭХ БУУДЛЫГ ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
БАЙГУУЛЛАГЫН 4С ХЯНАЛТЫН КОД БҮХИЙ АГААРЫН ХӨЛӨГ ХҮЛЭЭН АВАХ ХҮЧИН  
ЧАДАЛТАЙ АЭРОДРОМ, ЗОРЧИГЧ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БҮХИЙ ОЛОН УЛСЫН  
НИСЭХ БУУДАЛ БОЛГОХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 11 дугаар сарын 17 -ны өдөр

Дугаар: 36

№	Агуулга	Тайлбар
1	Судалгааны нэр	Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын иргэний нисэхийн байгууллагын 4С хяналтын код бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудал болгох төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах.
2	Судалгааг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага	<ul style="list-style-type: none"><li>Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8 дугаар бүлгийн 8.1 дэх хэсгийн 5-д "Шинэ нийслэл болон Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудыг 4С зэрэглэлийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудалтай болгоно" гэж тус тус заасан;</li><li>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 1.3 "Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ", 1.3.1-т "Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, 6 нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт болгосон байна";</li><li>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3 дугаар бүлгийн 3.6.4-т "Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, өрсөлдөөнийг бий болгож, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулах";</li><li>Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоолын 3.2 "Баруун бүс"-ын 3.2.3-т "Увс, Ховд аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө", 3.3 "Хойд бүс"-ын 3.3.3-т "Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө", 3.5 "Зүүн бүс"-ийн 3.5.4-т "Дорнод аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө", 3.6 "Говийн бүс"-ийн 3.6.9-т "Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын болгон өргөтгөнө" гэж тус тус заасан.</li></ul> <p>Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.6 "Зүүн бүс"-Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд</p>

		эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс"-ын 1.3.6.1-т "Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна", 1.4.1 "Шилжилт хөдөлгөөн"-ийн 1.4.1.6-т "Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно", 3.3.2. "Боомтын шинэчлэл, тээвэр, логистик"-ын 3.3.2.11-т "Орон нутгийн нисэх буудлуудыг 4С, 4D ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ", 3.2.3-т "Увс, Ховд аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө".
3	Захиалагч	Зам, тээврийн яам; Иргэний нисэхийн ерөнхий газар.
4	Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах байгууллага	Аэродром, нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, дэд бүтэц, техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, аэродромын барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах туршлагатай эрх бүхий мэргэжлийн байгууллага. Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулж байсан туршлагатай байх.
5	Судалгааг хэрэгжүүлэх хугацаа	Судалгааны ажлыг Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулснаас хойш 6 сарын дотор хийж гүйцэтгэнэ.
6	Зорилго	Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахтай холбоотойгоор дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:  <u>Зах зээлийн судалгаа боловсруулах:</u> <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн макро орчны судалгаа;</li> <li>• Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ;</li> <li>• Агаарын тээврийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон дунд, урт хугацааны зорчигчдын ачаалал, ачаа урсгалын эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын талаар судалгаа;</li> <li>• Тус нисэх буудлын гол харилцагч талуудын талаар судалгаа;</li> <li>• Олон улсын агаарын зам, түүнтэй уялдуулан хөгжүүлэх судалгаа;</li> <li>• Аэродром, нисэх буудлын үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох.</li> <li>• Хүн ам зүйн судалгаа;</li> <li>• Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ</li> <li>• Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн өнөөгийн байдлын шинжилгээ</li> </ul> <u>Техникийн магадлалын судалгаа боловсруулах:</u> <ul style="list-style-type: none"> <li>• Аэродромын хүчин чадал, ерөнхий үзүүлэлт;</li> <li>• Төслийн талбайн газар зүйн солбицол бүхий зураг, геологийн тогтцын судалгаа, газар хөдлөл, чичирхийллийн судалгаа, ус зүй, цаг уурын төлөв байдлын судалгаа зэрэг;</li> <li>• 2018 онд "ЭЗТ" ХХК-иар гүйцэтгүүлсэн Ховд нисэх буудлын аэродромын өргөтгөлийн ажлын зураг төсөлд тодотгол хийх, шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөлийг шинэчлэх;</li> <li>• 2018 онд "ЭЗТ" ХХК-иар гүйцэтгүүлсэн Ховд нисэх буудлын аэродромын өргөтгөлийн ажлын зураг төсөвт тодотгол хийх;</li> <li>• 2020 онд "Алтайн газрын хүч" ХХК-иар гүйцэтгүүлсэн Зөрчил үйлчилгээний барилга болон бусад инженерийн барилга</li> </ul>

- байгууламжийн ажлын зураг төсөлд тодотгол хийх, шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөлийг шинэчлэх;
- 2020 онд "Алтайн газрын хүч" ХХК-иар гүйцэтгүүлсэн Зорчигч үйлчилгээний барилга болон бусад инженерийн барилга байгууламжийн ажлын зураг төсөвт тодотгол хийх;
  - Талбайн зургийг боловсруулах;
  - Технологийн схем, технологийн холбоос зураг, нисэх буудлын үйлчилгээний процесс бүрийн технологийн схем зэрэг;
  - Шаардлагатай тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоо ширхгийн талаар судалгаа;
  - Аэродром, нисэх буудлын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой байгууллагын бүтэц, орон тоо, ажиллах хүчинд тавигдах шаардлагын талаар судалгаа;
  - Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
  - Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчид тавигдах шаардлага болон барилгын ажлын ерөнхий төлөвлөгөө.

Төслийн анхны хөрөнгө оруулалтын задаргааг боловсруулах:

- Төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд;
- Барилга байгууламжтай холбоотой зардлууд;
- Дэд бүтэцтэй холбоотой зардлууд;
- Машин, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд;
- Тээврийн хэрэгсэл, компьютер, бусад хэрэгсэл, тавилга, эд хогшил;
- Биет бус хөрөнгө;
- Санхүүгийн өртөг;
- Эргэлтийн хөрөнгийн зардал.

Санхүүгийн төсөөлөл, үр ашгийн тооцооллын судалгаа боловсруулах:

- Аэродром, нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор шаардагдах нийт санхүүжилт, түүний зарцуулалтын задаргаа;
- Капиталын оновчтой бүтцийг хэрхэн бүрдүүлэх талаар судалгаа;
- Үйлчилгээний үнэ, тариф, борлуулалтын төсөөллийн талаар судалгаа;
- Аэродром, нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотойгоор гарах зардлын судалгаа;
- Санхүүжилтийн зардлын судалгаа;
- Санхүүгийн загвар;
- Ирээдүйн капиталын хэрэгцээг тодорхойлох;
- Санхүүгийн үр дүнгийн ерөнхий үзүүлэлтүүд /NPV, IRR, хөрөнгө оруулалт нөхөх хугацаа, ашгийн түвшин гэх мэт/;
- Мэдрэмжийн шинжилгээ.
- Төслийн эрсдэлийн шинжилгээ
- Төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Хууль эрх зүйн орчны судалгааг боловсруулах:

Нийгэм-эдийн засаг, байгаль орчны судалгаа боловсруулах:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Иргэний нисэхийн ерөнхий газрын захиалгаар 2019 онд гүйцэтгэсэн тайланд тулгуурлан дүгнэлтийг гүйцэтгэх;
- Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ;
- Хөдөлмөр эрүүл ахуй, нийгмийн менежмент

7	Судалгааны ажлын хамрах хүрээ, гарах үр дүн	Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын иргэний нисэхийн байгууллагын 4С хяналтын код бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудал болгох төслийн <b>ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЙЛАН.</b>
8	Судалгааны багт тавигдах шаардлага	<p>Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэх баг дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:</p> <p><u>Багийн ахлагч: Агаарын тээврийн эдийн засагч:</u> Судалгааны ажлыг хэрэгжүүлэх гэрээ баталгаажсан үеэс эхлэн хэрэгжилтийг зохион байгуулж, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хэмжээнд чанартай гүйцэтгэх, зөвлөхүүдийн хийх ажилд хяналт тавих, хийх ажлыг төлөвлөх, тайлан гаргахад хяналт тавьж, холбогдох байгууллагуудаас санал авах, санал зөвлөмжийг тайланд тусгах ажлуудыг зохион байгуулан, ажлыг гэрээнд заасны дагуу хугацаанд нь гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. Бодлогын хувилбарын уялдааг хангана. Мөн тайлангийн явц, эцсийн тайлангийн талаар хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулна. Тээврийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, магистр болон түүнээс дээш зэрэгтэй хүн байна.</p> <p><u>Аэродром хариуцсан зөвлөх:</u> Аэродромын хийц, зураг төсөлд стандартын шаардлагын дагуу үнэлэлт дүгнэлт, аюулгүйн ажиллагааны эрсдэлийн менежмент, аэродромын төлөвлөгөө, санал, зөвлөмж боловсруулна. Зөвлөх нь иргэний нисэхийн салбарын аэродромын инженер байна.</p> <p><u>Нислэг хөдөлгөөний менежмент хариуцсан мэргэжилтэн:</u> Иргэний нисэхийн аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр мэргэшсэн навигацийн тоног төхөөрөмжийн мэдлэгтэй, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүн байна.</p> <p><u>Хууль эрх зүйн зөвлөх:</u> Хууль эрх зүйн зөвлөмж гүйцэтгэх чадвартай байх бөгөөд судалгааны явцад болон төслийн хэрэгжилтэд хууль эрх зүйн талаас тулгарах асуудлуудыг дэвшүүлэн, зөвлөмж боловсруулна. Олон улсын болон Монгол Улсын эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүн байна.</p> <p><u>Архитектур:</u> Нисэх буудлын барилгын зураг, төсвийг боловсруулах үүрэг бүхий архитектурын бакалавр болон түүнээс дээш, Монгол Улсын мэргэшсэн зэрэгтэй хүн байна.</p> <p><u>Барилгын инженер:</u> Нисэх буудлын барилгын зураг, төсвийг боловсруулах үүрэг бүхий барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш, Монгол Улсын мэргэшсэн зэрэгтэй хүн байна.</p> <p><u>Байгаль орчин, нийгэм эдийн засгийн хариуцсан мэргэжилтэн:</u> Байгаль орчны менежмент, нийгэм эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн 10-аас доошгүй жил ажилласан дадлага, туршлагатай хүн байна.</p> <p><u>Туслах ажилтан (1 хүн):</u> Судалгааны ажлын хэрэгжилтийн хугацаанд ажиллан, зөвлөхүүдийн зааврын дагуу компьютерт судалгааны дүн, нэгтгэх, хэвлэх, олшруулах ажлуудыг гүйцэтгэнэ. <b>МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН ТӨСВИЙН АЖЛАХ, ТЭЭВРИЙН ЯАМ</b></p>

**ЭХ ХУВЬ**  
 Соёд Төрийн Иргэний Бишгийн  
 даргын 2011 оны 36 дугаар гэрээ

9	Судалгааны тайлангийн үе шат	<p><u>Явцын тайлан:</u> Судалгааны ажлын явцын дэлгэрэнгүй тайланг Захиалагч талд сар бүрийн 10-ны өдрийн дотор хүргүүлэх.</p> <p><u>Эцсийн тайлан:</u> Дээр дурдсан судалгааны ажлуудыг нэгтгэсэн ТЭЗҮ-ийн тайлан болон бусад холбогдох зураг, төсөв, үнэлгээний тайлангуудыг <b>Монгол/Англи</b> хэл дээр тус бүр хэвлэмэл болон файл хэлбэрээр захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг (Soft хэлбэрээр 5 хувь) хүлээлгэж өгнө. Мөн тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls өргөтгөлөөр, байрзүйн зураглалд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгнө.</p>
---	------------------------------	---

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ИРГЭНИЙ  
НИСЭХИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



Г.БАТБАЯР

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА



Ч.МӨНХТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ИНЕГ-ЫН НИСЭХ БУУДЛЫН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Э.МӨНХ-ЭРДЭНЭ

